

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ № 01 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 09.50 цагт эхэлж, 11.40 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 50 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан Ж.Жамъянтивын гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	<p>1.Жамъянжавын Жамъянтивыг Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалаас хууль зүйн үндэслэлгүй чөлөөлөн, тухайн албан тушаалын нөөцөд байгаагүй иргэн П.Нямжавыг Засаг даргын Тамгын газрын даргаар түр томилсон Завхан аймгийн Засаг даргын 2008 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 268 тоот захирамж нь Төрийн албаны тухай хуулийн 4.2.5, 19.2, 27.2.1, 27.2.2, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5.1.3, 12.3, 45, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дэх заалтууд болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан ушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус зөрчсөн байна гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг үндэслэн Завхан аймгийн Засаг даргын 2008 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 268 тоот захирамжийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэх.</p> <p>2.Завхан аймгийн Засаг даргын 2008 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 268 тоот захирамжийг хүчингүй болгох.</p> <p>3.Жамъянжав овогтой Жамъянтивыг Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд эгүүлэн томилохыг Засаг дарга Я.Санжмятавт үүрэг болгох.</p> <p>4.Завхан аймгийн Засаг даргын 2008 оны 268 тоот захирамжийн улмаас төрд учирсан хохирлыг тооцож, төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны (Ц.САМБАЛЛ-ХҮНДЭВ)-д үүрэг болгосон тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарсан.</p>
2	Зарим иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу тэднийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	Төрийн албаны зөвлөлд гаргасан хүсэлт болон Төрийн албаны тухай хуулийн 17.11-д заасныг үндэслэн Цэвээндоржийн Ням-Осор, Аукетайн Мурат, Жигмэдцэдэнгийн Хүрэлсүх, Пүрэвжавын Гансүх, Гаадангийн Шархүү, Раднаагийн Эрдэнэцогт, Батаагийн Батхүү нарыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэсэн тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарсан
3	Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил	Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил

- үүргийн хуваарийн тухай
- үүргийн хуваарийг баталсан Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарсан. Комисс байгуулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарав.
- 4 Үндэсний татварын ерөнхий газрын дарга, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисс томилох тухай
- 5 Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
- 6 "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнах журмын тухай
- 7 Сүхбаатар аймгийн Засаг даргын 2008 оны 464 дүгээр захирамж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 54 дүгээр тушаалыг хүчингүй болгох тухай
- 8 Бусад асуудал:
- 1)Монгол Улсын Төрийн албан хаагчийн 2008 оны нөхөн тоо бүртгэлийн дүнгийн тухай
- 2)Төрийн албаны тухай хуулийн 10.6 дахь заалтын дагуу төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчид аливаа улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзсэн байх тухай
- Яамны бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг шийдвэрлэсний дараа хэлэлцэхээр хойшлуулав.
- Хойшлуулсан.
- 1.Нээлттэй сонгон шалгаруулалтад орж томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаал болох Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар тухайн албан тушаалын нөөцөд байгаагүй иргэн П.Мөнхжаргалыг, мөн төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөөгүй иргэн Б.Буян-тогтохыг Нийгмийн бодлого, зохицуулалтын хэлтсийн даргаар түр томилж Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12.1.8, 45.5 дахь заалтууд болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгоншалгаруулах журам"-ыг зөрчсөн Сүхбаатар аймгийн Засаг даргын 2008 оны 464 тоот захирамж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 54 тоот тушаалыг тус тус хууль зүйн үндэслэлгүй гэж үзэх.
- 2.Сүхбаатар аймгийн Засаг даргын 2008 оны 464 тоот захирамж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 54 тоот тушаалыг тус тус хүчингүй болгох.
- 3.Сүхбаатар аймгийн Засаг даргын 2008 оны 464 тоот захирамж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 54 тоот тушаалын улмаас төрд учирсан хохирлыг тооцож, төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (Ц.САМБАЛЛХҮНДЭВ)-д үүрэг болгосон тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарсан.
- 1.Монгол Улсын Төрийн албан хаагчийн 2008 оны нөхөн тоо бүртгэлийн дүнг эцэслэн, цаашид энэ мэдээллээ хэрхэн, яаж ашиглах вэ? гэдгийг тодорхой болгох үүрэг (хариуцсан төслийн нэгж, комисст)-гийг өгөв.
- 2.Намын гишүүнчлэлээс түдгэлзэх асуудал үндсэндээ дуусах шатандаа орлоо. Зарим нэг хүн ямар нэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хамрагдаагүй үлдсэн байгаа байх, тийм учраас Зөвлөлийн гишүүн Б.Өнөбаатар гишүүн үлдсэн хүмүүсийг хамруулж дуусах ажлыг хариуцахыг даалгав.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

